

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2020 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт
БШУС	Боловсрол шинжлэх ухааны сайд
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НБББББ	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг

Агуулга

1.ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	5
3.Аудитын тайлан.....	14
3.1. Ерөнхий зүйл.....	14
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	14
3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт	15
3.4. Материаллаг байдал	15
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	16
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	17
3.7. Шилэн дансны мэдээлэл	18
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
3.9. Аудитын илрүүлэлт.....	18
Залруулсан алдаа	18
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил	19
Аудитын зөвлөмж.....	20
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд	20
4. Менежментийн захидал	21
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	24



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН
МОНГОЛ ТЭМҮҮЛЭЛ СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ Д.ТӨМӨРЧӨДӨР ТАНАА

2021.02.25 № 07/493
танай _____-ны № _____-т

Аудитын санал, дүгнэлт

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Ерөнхий боловсролын Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Аудитын хүрээнд бусад асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлтээ гаргахдаа тусдаа дүгнэлт гаргаагүй болно. Тайлант жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 100 хувиар биелүүлж ажилласан гэж тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Худалдан авалтыг цахимаар зохион байгуулаагүй шууд гэрээ байгуулсан 31,130.1 мянган төгрөг, өмнөх аудитаар өгсөн “жил бүр давтагдах шинжтэй үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөнд тусгах” зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 20,520.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөнд тусгалгүй нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж зарцуулсан зэрэг зөрчлүүд нь Төрийн

болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3 дахь заалтууд болон Үнэн зөв байх, Үнэлгээ ба хувиарлалт батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүү байдлын тайлан

/төгрөгөөр/			
Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	139,202,939.53	154,761,394.28
33	АВЛАГА	303,742.37	562,526.30
33500	Бусад авлага	303,742.37	562,526.30
33510	Байгууллагаас авах авлага	303,742.37	562,526.30
35	БАРАА МАТЕРИАЛ	138,899,197.16	154,198,867.98
35400	Хангамжийн материал	138,899,197.16	154,198,867.98
35410	Бичиг хэргийн материал	1,199,667.00	2,028,892.00
35420	Аж ахуйн материал	126,931,655.16	139,981,685.98
35440	Түлш, шатах тослох материал	77,805.00	1,263,500.00
35460	Хүнсний материал	1,686,080.00	1,144,750.00
35470	Бусад хангамжийн материал	9,003,990.00	9,780,040.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	4,000,709,888.40	3,957,491,959.83
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,000,709,888.40	3,957,491,959.83
39200	Биет хөрөнгө	3,997,837,433.51	3,956,433,686.90
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,456,901,301.72	3,456,901,301.72
39202	Хуримтлагдсан элэгдэл	(131,168,255.66)	(191,707,450.58)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	98,458,333.00	98,458,333.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(92,988,425.80)	(98,458,333.00)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	195,301,089.44	272,979,199.44
39206	Хуримтлагдсан элэгдэл	(102,612,699.52)	(155,156,435.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	170,879,233.90	223,959,183.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(115,575,355.21)	(138,705,189.96)
39214	Бусад үндсэн хөрөнгө	653,998,698.28	653,998,698.28
39215	Хуримтлагдсан элэгдэл	(146,063,986.64)	(179,771,060.48)
39217	Ном	10,707,500.00	13,935,440.00
39300	Биет бус хөрөнгө	2,872,454.89	1,058,272.93
39301	Програм хангамж	6,627,546.00	6,627,546.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(3,755,091.11)	(5,569,273.07)
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	4,139,912,827.93	4,112,253,354.11
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	4,139,912,827.93	4,112,253,354.11
51	Засгийн газрын хувь оролцоо	4,139,912,827.93	4,112,253,354.11
51100	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	265,942,620.50	265,942,620.50
51200	Хуримтлагдсан үр дүн	3,873,970,207.43	3,846,310,733.61
51210	Өмнөх үеийн үр дүн	4,052,797,524.25	3,873,970,207.43
51220	Тайлант үеийн үр дүн	(178,827,316.82)	(27,659,473.82)
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	4,139,912,827.93	4,112,253,354.11

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,102,740,204.00	1,353,057,483.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	25,555,644.00	77,305,050.00
120	Нийтлэг татварын бус орлого	25,555,644.00	77,305,050.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	25,555,644.00	77,305,050.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	25,555,644.00	77,305,050.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,077,184,560.00	1,275,752,433.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	906,852,800.00	1,173,841,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	906,852,800.00	1,173,841,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,331,760.00	101,911,033.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,331,760.00	101,911,033.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,281,545,520.82	1,374,321,016.82
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,281,545,520.82	1,374,321,016.82
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,235,787,644.60	1,361,806,121.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	727,703,492.77	885,399,672.05
210101	Үндсэн цалин	727,703,492.77	885,399,672.05
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	93,653,552.86	112,290,613.88
210201	Тэтгэврийн даатгал	65,251,025.88	78,058,156.63
210202	Тэтгэмжийн даатгал	7,472,188.21	9,183,312.31
210203	ҮОМШӨ-ний даатгал	5,888,772.77	7,145,050.85
210204	Ажилгүйдлийн даатгал	1,322,043.43	1,609,535.01
210205	Эрүүл мэндийн даатгал	13,719,522.57	16,294,559.08
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,966,457.45	38,646,008.64
210301	Гэрэл, цахилгаан	27,854,740.00	15,577,807.47
210302	Түлш, халаалт	13,793,986.32	17,130,706.58
210303	Цэвэр, бохир ус	9,317,731.13	5,937,494.59
2104	Хангамж, бараа материалын зардал	16,725,154.23	39,423,190.49
210401	Бичиг хэрэг	1,301,740.00	2,708,850.00
210402	Тээвэр, шатахуун	3,004,760.00	4,052,705.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,914,654.23	20,017,435.99
210404	Ном, хэвлэл	0.00	146,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	580,000.00	7,448,860.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,924,000.00	5,049,339.50
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,162,994.50	887,150.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	3,162,994.50	887,150.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	101,920,204.00	76,386,756.18
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	101,592,804.00	74,572,726.18
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	0.00	186,030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	200,000.00	128,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	127,400.00	0.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	241,655,788.79	208,772,730.07
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	35,065,604.10	31,568,801.50
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	206,590,184.69	177,203,928.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,757,876.22	12,514,895.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,079,100.00	8,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,079,100.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,000,000.00	8,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,678,776.22	4,514,895.51

213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,478,941.22	4,404,224.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	199,835.00	110,671.36
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	(178,805,316.82)	(21,263,533.82)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	22,000.00	6,395,940.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	22,000.00	6,395,940.00
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	(178,827,316.82)	(27,659,473.82)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	1,077,184,560.00	1,275,752,433.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,077,184,560.00	1,275,752,433.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	906,852,800.00	1,173,841,400.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	906,852,800.00	1,173,841,400.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	170,331,760.00	101,911,033.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	170,331,760.00	101,911,033.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,077,184,670.00	1,218,095,433.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,077,184,670.00	1,218,095,433.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,031,426,793.78	1,205,580,537.49
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	731,412,247.00	884,911,897.00
210101	Үндсэн цалин	447,118,047.00	637,737,516.00
210102	Нэмэгдэл	159,416,300.00	180,913,670.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,520,000.00	37,170,568.00
210104	Урамшуулал	94,357,900.00	29,090,143.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	90,248,541.00	113,037,172.86
210201	Тэтгэврийн даатгал	59,505,106.00	78,018,677.86
210202	Тэтгэмжийн даатгал	6,955,420.00	7,410,678.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,878,625.00	6,982,817.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,537,605.00	3,169,023.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,371,785.00	17,455,977.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	50,966,457.45	38,646,008.64
210301	Гэрэл, цахилгаан	27,854,740.00	15,577,807.47
210302	Түлш, халаалт	13,793,986.32	17,130,706.58
210303	Цэвэр, бохир ус	9,317,731.13	5,937,494.59
2104	Хангамж, бараа материалын зардал	21,716,299.23	44,906,000.99
210401	Бичиг хэрэг	2,493,000.00	3,714,700.00
210402	Тээвэр, шатахуун	3,082,565.00	5,238,400.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	9,914,654.23	20,017,435.99
210404	Ном, хэвлэл	761,300.00	146,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	1,924,000.00	7,486,025.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,540,780.00	8,303,440.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	0.00	8,570,940.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	0.00	8,570,940.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	104,874,011.00	75,455,528.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	104,546,611.00	73,641,498.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.00	1,500,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	200,000.00	186,030.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	127,400.00	128,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	32,209,238.10	40,052,990.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	32,209,238.10	40,052,990.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	45,757,876.22	12,514,895.51
2132	Бусад урсгал шилжүүлэг	41,079,100.00	8,000,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	20,079,100.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	21,000,000.00	8,000,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,678,776.22	4,514,895.51
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	4,478,941.22	4,404,224.15
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	199,835.00	110,671.36

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(110.00)	57,657,000.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	0.00	57,657,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	0.00	57,657,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	0.00	57,657,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	57,657,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	0.00	(57,657,000.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(110.00)	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	110.00	0.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
1	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,942,620.50	4,052,797,524.25	4,318,740,144.75
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,942,620.50	4,052,797,524.25	4,318,740,144.75
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
8	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
9	Тайлант үеийн үр дүн	0.00	(178,827,316.82)	(178,827,316.82)
10	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	265,942,620.50	3,873,970,207.43	4,139,912,827.93
11	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	265,942,620.50	3,873,970,207.43	4,139,912,827.93
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	0.00
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	265,942,620.50	3,873,970,207.43	4,139,912,827.93
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.00	0.00	0.00
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.00	0.00	0.00
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.00	0.00	0.00
18	Зарласан ногдол ашиг	0.00	0.00	0.00
19	Тайлант үеийн үр дүн	0.00	(27,659,473.82)	(27,659,473.82)
20	2020 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	265,942,620.50	3,846,310,733.61	4,112,253,354.11

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
	Эхний үлдэгдэл				
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,173,841,400.00	1,169,437,175.85	4,404,224.15	99.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,173,841,400.00	1,169,437,175.85	4,404,224.15	99.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,165,021,400.00	1,161,437,175.85	3,584,224.15	99.69
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	868,293,700.00	868,293,700.00	0.00	100.00
210101	Үндсэн цалин	628,154,800.00	621,119,319.00	7,035,481.00	98.88
210102	Нэмэгдэл	180,998,000.00	180,913,670.00	84,330.00	99.95
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,723,000.00	37,170,568.00	(5,447,568.00)	117.17
210104	Урамшуулал	27,417,900.00	29,090,143.00	(1,672,243.00)	106.10
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	111,670,600.00	111,120,544.86	550,055.14	99.51
210201	Тэтгэврийн даатгал	76,772,900.00	76,102,049.86	670,850.14	99.13
210202	Тэтгэмжийн даатгал	8,724,400.00	7,410,678.00	1,313,722.00	84.94
210203	ҮОМШӨ-ний даатгал	6,979,500.00	6,982,817.00	(3,317.00)	100.05
210204	Ажилгүйдлийн даатгал	1,744,900.00	3,169,023.00	(1,424,123.00)	181.62
210205	Эрүүл мэндийн даатгал	17,448,900.00	17,455,977.00	(7,077.00)	100.04
2104	Хангамж, бараа материалын зардал	40,905,300.00	39,577,800.99	1,327,499.01	96.75
210401	Бичиг хэрэг	3,222,000.00	3,222,000.00	0.00	100.00
210402	Тээвэр, шатахуун	4,743,400.00	4,743,400.00	0.00	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	20,110,000.00	19,639,935.99	470,064.01	97.66
210404	Ном, хэвлэл	1,071,900.00	1,071,900.00	0.00	100.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	4,820,000.00	4,327,125.00	492,875.00	89.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	6,938,000.00	6,573,440.00	364,560.00	94.75
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	63,000,000.00	63,000,000.00	0.00	100.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	63,000,000.00	63,000,000.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	39,040,000.00	38,882,100.00	157,900.00	99.60
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	37,132,000.00	37,068,070.00	63,930.00	99.83
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	230,000.00	186,030.00	43,970.00	80.88
210804	Тээврийн хэрэгслийн татвар	128,000.00	128,000.00	0.00	100.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,000.00	0.00	50,000.00	0.00

2109	Бараа үйлчилгээний бусад зардал	42,111,800.00	40,563,030.00	1,548,770.00	96.32
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	42,111,800.00	40,563,030.00	1,548,770.00	96.32
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	8,820,000.00	8,000,000.00	820,000.00	90.70
2132	Бусад урсгал шилжүүлэг	8,820,000.00	8,000,000.00	820,000.00	90.70
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	8,820,000.00	8,000,000.00	820,000.00	90.70
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,173,841,400.00	1,169,437,175.85	4,404,224.15	99.62
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,173,841,400.00	1,169,437,175.85	4,404,224.15	99.62
310001	Улсын төсвөөс санхүүжих	1,173,841,400.00	1,169,437,175.85	4,404,224.15	99.62
	Тохируулгын дүн				
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
	Ажиллагсдын тоо	41	41		100.00
	Удирдах ажилтан	1	1		100.00
	Гүйцэтгэх ажилтан	31	31		100.00
	Үйлчлэх ажилтан	9	9		100.00

2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан

Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл /төгрөгөөр/
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		101,911,033.00
УРСГАЛ ЗАРДАЛ		101,911,033.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		101,911,033.00
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил		16,618,197.00
Үндсэн цалин		16,618,197.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл		1,916,628.00
Тэтгэврийн даатгал		1,916,628.00
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал		38,646,008.64
Гэрэл, цахилгаан		15,577,807.47
Түлш, халаалт		17,130,706.58
Цэвэр, бохир ус		5,937,494.59
Хангамж, бараа материалын зардал		6,254,100.00
Бичиг хэрэг		492,700.00
Тээвэр, шатахуун		495,000.00
Шуудан, холбоо, интернэтийн төлбөр		377,500.00
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал		3,158,900.00
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс		1,730,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж		36,573,428.00
Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж		36,573,428.00
Бараа үйлчилгээний бусад зардал		1,792,000.00
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх		1,792,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		110,671.36
Олгосон санхүүжилт, шилжүүлэг		110,671.36
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		110,671.36
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		101,911,033.00
Нэмэлт санхүүжилтийн орлого		101,911,033.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		101,911,033.00
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		

3.Аудитын тайлан

3.1. Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан бүрэн эрхийн хүрээнд Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг тус байгууллагын захирал Д.Төмөрчөдөр танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч этгээдэд бараа материал, үндсэн хөрөнгийг стандартын дагуу бүртгэх, анхан шатны баримтын бүрдлийг хангаж ажиллах, үр дүнгийн урамшууллыг засгийн газрын тогтоолд тусгагдсан хувь хэмжээнээс хэтрүүлэхгүй олгох талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 01 дүгээр сарын 25-наас 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Мишээл-Од Аудит ХХК-ийн захирал Т.Одончимэг, чанарын хяналтын менежер Э.Энхцэцэг, ахлах аудитор О.Цэндхүү, аудиторов туслах М.Батмагнай, П.Гэндэнсүрэн нар хариуцаж хэрэгжүүлэв.

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Үндэсний аудитын газарт 2021 оны 01 сарын 19-ний өдрийн 01/002 тоот албан бичгээр ирүүлсэн байна.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилгоо чанартай боловсрол олгож, дэлхийд өрсөлдөхүйц чадвартай Монгол иргэнийг бэлтгэхэд оршино гэж тодорхойлсон.

Дээрх зорилгын хүрээнд тус сургууль нь өөрийн дүрэмдээ 13 үйл ажиллагааны чиглэлийг тодорхойлон хэрэгжүүлж ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

Монгол улсын хууль:

- Коронавируст халдвар /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль

Засгийн газрын тогтоол:

- Засгийн газрын 2020 оны 78, 114 дүгээр тогтоолоор баталсан “Бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 32 дугаар тогтоолоор баталсан “Боловсролын салбарт хэрэгжүүлэх арга хэмжээний тухай”

- Засгийн газрын 2020 оны 139, 168 дугаар тогтоолоор баталсан “Коронавируст халдвар (covid-19)-аас урьдчилан сэргийлэх чиглэлээр боловсролын салбарт авч хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 183, 188 дугаар тогтоолоор баталсан “Бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 195 дугаар тогтоолоор баталсан “Төрийн бус өмчийн цэцэрлэг, ерөнхий боловсролын сургууль мэргэжлийн боловсрол сургалтын зарим байгууллагын талаар авах арга хэмжээний тухай”
- Засгийн газрын 2020 оны 207 дугаар тогтоолоор баталсан “Үндэсний хөтөлбөр Сайдын тушаал:
- БШУС-ын 2020 оны 162 дугаар тогтоолоор баталсан “Хүнсний дэмжлэг үзүүлэх тухай тушаал”

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын тогтоол:

- ТӨБЗГ-ын 2020 оны 49 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай”
- ТӨБЗГ-ын 2020 оны 50 дугаар тогтоолоор баталсан “Төрийн өөрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн талаар авах зарим арга хэмжээний тухай”

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь БШУС-ын 2017 оны бодлогын баримт бичиг, журам батлах тухай А/40 дүгээр тушаалаар баталсан сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагад мөрдөгдөх бодлогын баримт бичгийг мөрдөн ажиллаж байна. Тус бодлогын баримт бичгийг салбарын хэмжээнд шинэчлэн боловсруулж 2021 оны 2 сард шинэчилсэн НБББББ-ийг мөрдөхөөр болсон байна.

Тайлант хугацаанд Боловсрол, шинжлэх ухааны яамны Хяналт, шинжилгээ, үнэлгээ дотоод аудитын газраас шалгалт хийгдээгүй байна.

3.4. Материаллаг байдал

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, эрсдэлийн түвшинг төлөвлөлтийн үе шатанд “Бага” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 2 хувиар, гүйцэтгэлийн үе шатанд эрсдэл “Дунд” гэж үзээд 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,123,944.0 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 22,478.9 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсоныг гүйцэтгэлийн үе шатанд 2020 оны жилийн эцсийн санхүү үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1,380,716.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 13,807.2 мянган төгрөгөөр тооцлоо. Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын хувь хэмжээг бууруулсан нь эрсдэл их гэж тооцсонтой холбоотой болно.

3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 27,659.5 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө, өмчийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

			/мянган төгрөг/
Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	303.7	562.5	258.8
Бараа материал	138,899.2	154,198.9	15,299.7
Үндсэн хөрөнгө	4,000,709.9	3,957,491.9	(43,218.0)
Нийт хөрөнгө	4,139,912.8	4,112,253.3	(27,659.5)
Өр төлбөр			-
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	4,139,912.8	4,112,253.3	(27,659.5)
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	4,139,912.8	4,112,253.3	(27,659.5)

Бараа материалын дансны үлдэгдэл 154,198.9 мянган төгрөг болж 15,299.7 мянган төгрөгөөр өссөн нь Ковид цар тахлын үед сурагчдын сургалтын материалын зарцуулалт буурсан, ашиглалтад тавьж олгосон бараа материалыг зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүйгээс шалтгаалжээ. Бараа материалын дансны үлдэгдэлд насжилт өндөртэй, ашиглалтгүй, нөөц үүсгэн худалдан авсан бараа материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 3,957,491.9 мянган төгрөг болж 43,218.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант хугацааны элэгдлийн зардлаар дансны үнэ буурснаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал санхүүжилтээр 57,657.0 мянга, Боловсрол, шинжлэх ухааны яамны хөрөнгө оруулалтаар 75,999.0 мянга, бусад хандив тусламжаар 330.0 мянган төгрөгийн хөрөнгийг шинээр хүлээн авсан, данснаас хассан үндсэн хөрөнгө байхгүй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,112,253.3 мянган төгрөг болж 27,659.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүн 27,659.5 мянган төгрөгөөр буурснаас шалтгаалжээ.

Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 250,317.3 мянган төгрөгөөр буюу 22.7 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан урсгал үйл ажиллагааны санхүүжилт байна.

Энэ нь өмнөх оноос 2020 оны хичээлийн жилд сурагчдын тоо 66 хүүхдээр нэмэгдсэн тул багшлах орон тоо нэмэгдсэн мөн үүнтэй холбоотойгоор хичээлийн хэрэгсэл болон эд хогшил худалдан авах зардал нэмэгдсэнтэй холбоотой байна.

Нийт зардал өмнөх оноос 99,149.4 мянган төгрөгөөр буюу 7.8 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, хөлс болон нэмэгдэл урамшил, байр ашиглалттай холбоотой зардал, хангамж бараа материалын зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж, бараа ажил үйлчилгээний бусад зардлууд байна. Энэ нь сурагчдын тоо нэмэгдсэнтэй холбоотой багшлах боловсон

хүчин нэмэгдсэн болон сургуулийн нүүлгэн шилжүүлэлт хийгдсэнтэй холбоотойгоор эдгээр зардлууд нэмэгдсэн байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,381,849.0 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 1,380,139.2 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 206,297.8 мянган төгрөгөөр бууруулж 1,173,841.4 мянган төгрөгөөр баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх үндсэн үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөл арга хэмжээг санхүүжүүлэхээр 1,173,841.4 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 1,173,841.4 мянган төгрөгийн санхүүжилт авч, урсгал үйл ажиллагаанд 1,169,437.2 мянган төгрөгийг дутуу зарцуулж 4,404.2 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,169,437.2 мянган төгрөг буюу 99.6 хувьтай байгаа нь хангамж бараа материалын зардлыг 1,327.5 мянган төгрөгөөр, бараа ажил үйлчилгээний бусад зардлыг 1,548.8 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь Боловсрол, шинжлэх ухааны бодлого удирдлага хөтөлбөрийн үндсэн үйл ажиллагааны зардал арга хэмжээ 4,404.2 мянган төгрөгөөр дутуу зарцуулагдсантай холбоотой байна.

Д/Д	Хөтөлбөр, арга хэмжээний		Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
	Код	Нэр				
1	71808	Боловсрол, ШУ-ны бодлого удирдлага	1,173,841.4	1,169,437.2	(4,404.2)	99.6
1.1	80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	1,165,021.4	1,161,437.2	(3,584.2)	99.7
1.3	80802	Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	8,820.0	8,000.0	(820.0)	90.7

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 101,911.0 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс цалин нийгмийн даатгалын зардалд 18,534.8 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардалд 38,646.0 мянга, хангамж, бараа материалын зардалд 6,254.1 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрт 36,573.4 мянга, бараа ажил, үйлчилгээний бусад зардалд 1,792.0 мянган төгрөг нийт 101,800.3 мянган төгрөгийг зарцуулж, дутуу зарцуулсан 110.7 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 153 мэдээллээс хугацаандаа оруулсан 147 мэдээлэл, хугацаа болоогүй 2 мэдээлэл, хугацаа хоцроосон 4 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулсан байна.

Шилэн дансанд байршуулсан мэдээллийг нягтлан бодох бүртгэлийн журналтай тулган шалгахад дараах байдалтай байна. Үүнд:

- Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 10 удаагийн 99,407.9 мянга, худалдан авалтын 7 удаагийн 49,387.9 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд дутуу байршуулсан,
- Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 7 харилцагчтай холбоотой 30,052.4 мянган төгрөгийн гэрээний мэдээлэл болон хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой шийдвэрийг байршуулаагүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 181,081.7 мянган төгрөгийн зөрчилд 146,591.7 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 1 албан шаардлагыг биелүүлж ажилласан байна. Аудитаар өгсөн 34,490.0 мянган төгрөгийн 3 зөвлөмжийн хэрэгжилт 31 хувьтай байна.

Хүснэгт 3 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт

/мянган.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Албан шаардлага	1	146,591.7	1	146,591.7			100.0
Зөвлөмж	3	34,490.0	2	10,700.0	1	23,790.0	69.0
Нийт дүн	4	181,081.7	3	157,291.7	1	23,790.0	13.1

Хэрэгжүүлээгүй 23,790.0 мянган төгрөгийн 1 зөвлөмжид албан шаардлага хүргүүлэв.

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 86,815.9 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 4,747.2 мянган төгрөгийн алдааг залруулж, 51,650.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлж, 30,418.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 4 зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа

Аудитаар нягтлан бодох бүртгэлийн бичилт, тооцоолол болон тайлагналын алдаатай дараах залруулгыг санхүүгийн тайланд тусгаж, баталгаажуулав. Үүнд:

1. Цалин хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос суутгасан орлогын албан татварын тайланд 3,844.2 мянган төгрөгийн татвар ногдох орлогыг дутуу тайлагнасан;

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөрөнгийн ашиглах хугацаанаас өөр хугацаагаар хөрөнгийг элэгдүүлснээс 903.0 мянган төгрөгийн элэгдлийг илүү байгуулсныг залруулав.

Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил

Аудитаар 82,068.7 мянган төгрөгийн залруулагдаагүй алдаа, зөрчил илэрснээс 51,650.1 мянган төгрөгийн зөрчилд 4 албан шаардлага хүргүүлээ. Үүнд:

1. Худалдан авалтыг цахимаар зохион байгуулаагүй уламжлалт аргаар зохион байгуулсан 31,130.1 мянган төгрөгийн сонгон шалгаруулалт хийсэн нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2-т "Харьцуулалтын аргыг дараах байдлаар хэрэглэнэ" 33.2.1-т "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх" заалттай нийцэхгүй, үнэн зөв байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

2. Шилэн дансанд 4 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 10 удаагийн 99,407.9 мянган төгрөг, үүнээс худалдан авалтын 7 удаагийн 49,387.9 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд дутуу байршуулсан, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 7 харилцагчтай холбоотой 30,052.4 мянган төгрөгийн гэрээний мэдээлэл болон хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг байршуулаагүй нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална" 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх" 4.1.2-д "мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх" 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх" гэсэн заалттай нийцэхгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

3. Өмнөх аудитаар өгсөн "жил бүр давтагдах шинжтэй үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөнд тусгах" зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, тайлант хугацаанд 20,520.0 мянган төгрөгийн үйл ажиллагааны орлогыг төлөвлөгөөнд тусгалгүй нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж зарцуулсан. Энэ нь Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.4.2-д "төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогын тооцоо", 46 дугаар зүйлийн 46.2-т "Энэ хуулийн 46.1-д заасан төсвийг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батална", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3-т "үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах" гэж заасныг тус тус мөрдөөгүй, тохиолдсон байх, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

4. Тайлант онд 000012659 дугаартай 3782 м2 газар эзэмших эрхийг шинээр гаргуулан авсныг санхүүгийн тайланд тусгаагүй байна. Энэ нь Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 4-т "Үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрх, дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийг Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулах" гэж заасныг мөрдөөгүй, үнэн зөв байх, иж бүрэн байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэх

Аудитын зөвлөмж

Аудитаар илэрсэн 30,418.6 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 4 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд

Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 3,456,901.3 мянган төгрөгийн барилга байгууламжийг тайлант онд өөрийн үйл ажиллагаанд ашиглаагүй, түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байна. Мөн тус барилга байгууламжид хамаарах 60,539.2 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг тайлант хугацааны зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн боловч үүнтэй холбоотой тус хөрөнгийн үр өгөөжийг хүртэхгүй байна.

Мөн Худалдаа үйлдвэрлэлийн их сургуультай 2020/57 тоот “Ашиглалтын гэрээ” байгуулан хичээлийн байрыг түрээсээр ашиглаж, тайлант онд хамаарах 383,524.5 мянган төгрөгийн түрээсийн зардлыг БШУЯ хариуцан төлж, тус сургуулийн зардлаар хүлээн зөвшөөрч бүртгээгүй байгаа зэрэг асуудлуудыг анхаарч үзэх нь зүйтэй гэж үзэж байна.

Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын улмаас аудитыг цахимаар хийж байгаатай холбоотой аудит хийх цар хүрээ хязгаарлагдаж, байгууллага дээр ажиллаж нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэн, анхан шатны баримт материалуудыг бүрэн хамруулах, төсвийн хяналтыг бүрэн хэрэгжүүлэх нөхцөл байдал хязгаарлагдмал байсныг дараагийн тайлант хугацаанд анхаарах нь зүйтэй гэж үзлээ.

4. Менежментийн захидал

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. Анхан шатны баримттай холбоотой асуудал

1.1. Илрүүлэлт:

Тайлант онд 132 харилцагчтай холбоотой 273,388.8 мянган төгрөгийн гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 6 харилцагчтай холбоотой 30,418.6 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй байна;

1.2. Эрсдэл:

Анхан шатны баримтын бүрдэл хангалтгүй гүйлгээг бүртгэлд тусгах;

1.3. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7 “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно” Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаалаар батлагдсан “Өмчийн бүх хэлбэрийн аж ахуйн нэгж, байгууллагад нийтлэг хэрэглэгдэх анхан шатны бүртгэлийн маягтыг нөхөх заавар”-ын 5 “Төлбөрийн баримт нь бараа, ажил, үйлчилгээний төлбөр, тооцоо хийгдсэнийг нотлох анхан шатны цаасан болон цахим баримт юм” гэсэн заалтын дагуу төлбөрийн баримтгүй ажил гүйлгээ хийхгүй байх, харилцагч байгууллагаас бүрэн гаргуулан авахад хяналт тавьж ажиллах;

1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Төлбөрийн баримтыг байгууллага бүрээс олон дахин нэхсэн ч авч чадаагүй энэ алдааг цаашид анхаарч ажиллана;

2. Балансын данстай холбоотой асуудал

2.1. Илрүүлэлт:

Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан дүрмийн сангийн хэмжээ нь санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүнгээс 4,052,797.4 мянган төгрөгөөр илүү тусгагдсан;

2.2. Эрсдэл:

Засгийн газрын оруулсан капитал зөрүүтэй илэрхийлэгдэх, холбогдох журмыг зөрчих;

2.3. Өгсөн зөвлөмж:

Хууль зүй дотоод хэргийн сайдын 2018 оны А/208 дугаар тушаалаар баталсан “Хуулийн этгээд, түүний салбар, төлөөлөгчийн газрын улсын бүртгэл хөтлөх журам”-ын 8.2 “Хуулийн этгээдийн дараах мэдээлэлд оруулсан өөрчлөлтийг хуульд өөрөөр заагаагүй бол ажлын 15 өдрийн дотор улсын бүртгэлд бүртгүүлнэ” 8.2.3 “хувь нийлүүлсэн хөрөнгө” заалтын дагуу улсын бүртгэлийн гэрчилгээнд өөрчлөлт оруулах;

2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үндсэн хөрөнгийн дүнгээр засгийн газрын оруулсан капитал тусгагдах ёстой гэж үзээд нэмэгдүүлсэн, дүрмийн санд өөрчлөлт оруулж залруулна.

3.Балансын данстай холбоотой асуудал

3.1. Илрүүлэлт:

- ✚ Үндсэн хөрөнгийн шинж чанартай 3 нэр төрлийн 9,006.8 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн;
- ✚ 28 нэр төрлийн 16,521.8 мянган төгрөгийн бараа материалыг ашиглалтад тавьж олгосон боловч зардлаар хүлээн зөвшөөрөөгүй;
- ✚ Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 73 нэр төрлийн 189,672.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй;

3.2. Эрсдэл:

Хөрөнгийн ангилал буруу илэрхийлэгдэх, холбогдох журмыг хэрэгжүүлж ажиллаагүй байх;

3.3. Өгсөн зөвлөмж:

- ✚ УСНББОУС 12 Бараа материал стандартын 44-т "Зардал гэж хүлээн зөвшөөрөх Барааг борлуулах, сольж арилжих, буюу түгээн хуваарилах тохиолдолд холбогдох орлогыг хүлээн зөвшөөрсөн тайлант үед тэдгээр бараа материалын дансны үнийг зардал гэж хүлээн зөвшөөрнө" гэсэн заалтын дагуу ашиглалтад тавьж олгосон бараа материалыг зарлагадах;
- ✚ Бараа материалын дансанд бүртгэгдсэн үндсэн хөрөнгийг шилжүүлэн бүртгэх;
- ✚ ТӨБЗГ-ын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журмын 7 дугаар зүйлийн 7.1 "Төрийн өмчит хуулийн этгээд нь эзэмшилдээ байгаа илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох саналыг бэлтгэн Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлж шийдвэрлүүлнэ" гэсэн заалтын дагуу элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоох;

3.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Зөрчлийг залруулж ажиллана.

4. Зардлын данстай холбоотой асуудал

4.1. Илрүүлэлт:

Тайлант онд сургуулийн захирлын тушаалуудаар нийт 4 удаа 49,811.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал багш ажилтнуудад олгосон ба үүнээс 12 дугаар сард 2 удаа тушаалаар нийт 8,700.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож Засгийн газрын 2019 оны 5 дугаар тушаалаар батлагдсан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3 хавсралтын 4 дүгээр заалтын 4.4-ын сар бүр тооцож, улирал бүр олгоно гэснийг мөрдөж ажиллаагүй 4 дүгээр улиралд 2 удаа олгосон байна.

4.2. Эрсдэл:

Засгийн газрын тогтоолыг зөрчиж урамшуулал олгосон байх;

4.3. Өгсөн зөвлөмж:

Засгийн газрын 2019 оны 5 дугаар тушаалаар батлагдсан Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журамд заасны дагуу үр дүнг сар бүр үнэлж, улирал бүр олгох заалтыг хэрэгжүүлж ажиллах;

4.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Үндсэн ажлаас гадна ажилчдын ажлын байрны тодорхойлолтод заагдаагүй нэмэлтээр шинэ байрны тохижилт нүүлгэлт, засвар теле цахим хичээл бэлтгэхэд зориулсан өрөөг бүрэн янзалж тохижуулах гэх мэт ажлыг ажлын бус цагаар нэмэлтээр дайчлан хийлгэсэн тул төсвийн шууд захирлын эрх мэдлийн хүрээнд ажилчдадаа хийсэнд тохирсон ажлын хөлсийг захирлын баталсан тушаалын дагуу олгосон.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2021.02.19	Аудитын нэр:	Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит			Аудитын код: САГ-2021/79/СТА-
Шалгагдсан байгууллагын нэр:		Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургууль			Мянган төгрөг
№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
1	2	3	4	5	6
1	Харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах 1 төрлийн 31,130.1 мянган төгрөгийн төгрөгийн худалдан авалтыг цахим системд байршуулаагүй шууд гэрээ байгуулсан	31,130.1	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
2	Тайлант онд 000012659 дугаартай 3782 м2 газар эзэмших эрхийг шинээр гаргуулсан авсныг санхүүгийн тайланд тусгаагүй байна.		Албан шаардлага хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
3	Тус байгууллагын санхүүгийн тайланд бүртгэлтэй 3,456,901.3 мянган төгрөгийн барилга байгууламжийг тайлант онд ашиглаагүй, түрээсийн байранд үйл ажиллагаа явуулж байгаа шинэ сургуулийн барилга баригдаж байгаа боловч өмнө нь ашиглаж байсан барилгыг данснаас хасаагүй байна		Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлах	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
4	Шилэн дансанд 4 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгийн орлого, зарлагын 7 удаагийн 49,387.9 мянган төгрөг, үүнээс худалдан авалтын 7 удаагийн 49,387.9 мянган төгрөгийн мэдээллийг шилэн дансанд дутуу байршуулсан, Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр хэсэгт 7 харилцагчтай холбоотой 30,052.4 мянган төгрөгийн гэрээний мэдээлэл болон хөрөнгө мөнгө зарцуулахтай холбоотой мэдээллийг байршуулаагүй байна.		Төсвийн ерөнхийлөн захирагчид уламжлах	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
5	Тайлант онд 132 харилцагчтай холбоотой 273,388.8 мянган төгрөгийн гүйлгээг татварын цахим системд бүртгэгдсэн төлбөрийн баримттай тулгахад 6 харилцагчтай холбоотой 30,418.6 мянган төгрөгийн төлбөрийн цахим баримтыг харилцагчаас гаргуулан аваагүй байна.	30,418.6	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг

6	Үндсэн хөрөнгийн шинж чанартай 3 нэр төрлийн 9,006.8 мянган төгрөгийн хөрөнгийг бараа материалын дансанд бүртгэсэн. Мөн 28 нэр төрлийн 16,521.8 мянган төгрөгийн бараа материалыг ашиглалтад тавьж олгосон боловч зардлаар хүлээн зөвшөөрөөгүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
7	Элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 73 нэр төрлийн 189,672.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоогоогүй байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
8	Тайлант онд сургуулийн захирлын тушаалуудаар нийт 4 удаа 49,811.9 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал багш ажилтнуудад олгосон ба үүнээс 12 дугаар сард 2 удаа тушаалаар нийт 8,700.0 мянган төгрөгийн үр дүнгийн урамшуулал олгож Засгийн газрын 2019 оны 5 дугаар тушаалаар батлагдсан төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журмын 3 хавсралтын 4 дүгээр заалтын 4.4-ын сар бүр тооцож, улирал бүр олгоно гэснийг мөрдөж ажиллаагүй 4 дүгээр улиралд 2 удаа олгосон байна.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
9	Өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, жил бүр давтагдах шинжтэй шалгалтын орлого 20,520.0 мянган төгрөгийн орлогыг төлөвлөгөөнд тусгаагүй нэмэлт санхүүжилтийн дансаар төвлөрүүлж зарцуулсан.	20,520.0	Албан шаардлага хүргүүлэх	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
10	Улсын бүртгэлийн гэрчилгээнд тусгагдсан дүрмийн сангийн хэмжээ нь санхүүгийн тайланд тусгагдсан төрийн өмчийн дүнгээс 4,052,797.4 мянган төгрөгөөр илүү тусгагдсан.		Зөвлөмж өгөх	Захирал Нягтлан бодогч	Д.Төмөрчөдөр. Х.Орхончимэг
ДҮН		82,068.7			



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР АЛБАН ШААРДЛАГА

2021 оны 02 дугаар сарын 25

№ 43/А0160058

Улаанбаатар хот

САН-2021/19/СТА-ТЧЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Харьцуулалтын аргаар сонгон шалгаруулах 31,130.1 мянган төгрөгийн худалдан авалтыг цахим системд зарлаагүй шууд гэрээ байгуулсан, байгууллагын шилэн дансанд 4 мэдээллийг хуулийн хугацаа хоцроож мэдээлсэн, 99,407.9 мянган төгрөгийн 10 удаагийн гүйлгээний мэдээлэл, 7 харилцагчтай холбоотой 30,052.4 мянган төгрөгийн гэрээний мэдээллийг байршуулаагүй, үйл ажиллагааны орлогыг төсвийн төлөвлөгөөнд тусгалгүйгээр 20,520.0 мянган төгрөгийн орлого төвлөрүүлж өмнөх аудитын зөвлөмжийг хэрэгжүүлээгүй, өөрийн байгууллагад бүртгэлтэй газар эзэмших эрхийг санхүүгийн тайланд тусгаагүй байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.2.1-т "үнийн санал ирүүлэх урилгыг энэ хуулийн 52.1.12, 53.5.4-т заасан худалдан авах ажиллагааны цахим системд зарлаж, үр дүнг тухай бүрд мэдээлэх", Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-т "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын 3.4.3-т "үндсэн үйл ажиллагааны буюу байгууллагын чиг үүргийг хэрэгжүүлэх явцад бий болдог жил бүр давтагдах шинжтэй тогтмол орлогыг төсөвт тусгахгүй орхигдуулах", Засгийн газрын 2020 оны 10 дугаар тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай" тогтоолын 4-т "Үнэлгээнд хамрагдаагүй газар эзэмших, ашиглах эрх, дахин үнэлгээ хийгдээгүй үл хөдлөх хөрөнгийг Засгийн газрын гишүүний баталсан аргачлалын дагуу үнэлж, 2020 оны санхүүгийн тайланд тусгах ажлыг зохион байгуулах" гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

Монгол Улс, Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, 1-р хороо, Бага тойруу-3, Засгийн газрын 4 дүгээр байр, Утас 51-264230

\\10.10.10.20\Bichig_Khereg\Alban Shaardiaga\2021\0225auditin 2-R Gazar29.Docx

001081117

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай, Шилэн дансны тухай, Сангийн сайдын 2019 оны 74 дүгээр тушаалаар баталсан "Төсвийн зарлагын хэмнэлт, үндсэн үйл ажиллагааны нэмэлт орлогыг зарцуулах, тайлагнах, нягтлан бодох бүртгэлд тусгах, хяналт тавих журам"-ын хэрэгжилтийг хангаж, биелэлтийг 2021 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор Үндэсний аудитын газарт ирүүлэх;
2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Ерөнхий боловсролын Монгол тэмүүлэл сургуулийн захирал Д.Төмөрчөдөр, нягтлан бодогч Х.Орхончимэг нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

АУДИТЫН ХОЁРДУГААР ГАЗРЫН ЗАХИРАЛ,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АХЛАХ АУДИТОР

МИШЭЭЛ-ОД АУДИТ ХХК-ИЙН АУДИТОР

Ц.НАРАНЧИМЭГ

Б.СЭРЖМЯДАГ

Т.ОДОНЧИМЭГ